

БАТЛАВ.

ЗАСАГ ДАРГА:

Л.МӨНХБАДРАХ

2019-02-12

ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хэрэгжүүлэх ажил   | Шалгуур үзүүлэлт  | Хугацаа  | Хариуцах эзэн   | Хүрэх үр дүн  |
|---|--|---|----------|---|---|
| 1 | Байгууллагын ил тод байдлын үйл ажиллагааг жигдрүүлж, админ эрхээр хариуцах албан хаагчийг чадавхижуулах арга хэмжээ авч ажиллах. Аймгийн сайтын нүүр дээр онцлох мэдээллийг тухай бүр байршуулж байх. | Цахим сайтад 7 хоног бүр мэдээллийг байршуулах. Байгууллагын мэдээлэл оруулах албан хаагчдад сургалт хийх.  | 2-р сард | Байгууллагын дарга нар<br>Б.Батсүрэн<br>Х.Хундмаа<br>Э.Сумъяа | Байгууллагын ил тод байдлын үйл ажиллагаа жигдэрнэ.             |
| 2 | И-оффиссын програмын хандалтаа нэмэгдүүлэх.  | И-оффиссын програмд хандалт багатай 12 албан хаагчийн хандалтыг нэмэгдүүлэх. Албан ажлын хүрээнд И-оффиссын програмаар файл илгээх, тайлан хүргүүлэхэд тогтмол ашиглах. | 2-р сард | Б.Амгаланжаргал   | И-оффиссын програмд 27 албан хаагчийн хандалт нэмэгдэнэ.        |
| 3 | 2019 онд тухайн байгууллагад ашиглагддаг хэвлэмэл хуудасны нэр төрөл, индексийг тогтоож, батлан гаргаж мөрдөх.   | Төсөвт байгууллагуудын хэвлэмэл хуудасны индексийг батлуулах  | 2-р сард | М.Баярмаа   | Засаг даргын захирамжаар хэвлэмэл хуудасны нэр төрөл, индексийг |

|   |   |   |          |                                    |   |
|---|---|---|----------|------------------------------------|---|
|   |   |   |          |                                    | батлуулж, мөрдөн ажилласан байна.   |
| 4 | СХЗҮТЗ-ийн 2011 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан баримт бичгийн стандартыг мөрдөж ажиллах.   | АЕГ-ын даргын тушаалаар батлагдсан албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврыг мөрдөн ажиллах | 2-р сард | М.Баярмаа                          | Төсөвт байууллагын үйл ажиллагаанд мөрдүүлж, хэрэгжилтэнд нь хяналт тавьж хэвшүүлсэн байна.   |
| 5 | Хариутай бичигт бүртгэлийн зааврын дагуу бүрэн хөтөлж, мэдээ тайланд тоо баримтыг бодитой тусгах.   | Хариутай бичгийн шийдвэрлэлтийг бүртгэл хяналтын картаар хяналт тавих                   | 2-р сард | М.Баярмаа                          | Хариутай мэдээ тайлангийн хоцрогдолгүй байх. СӨГ-ийн тайланг хугацаанд нь бодитой гаргаж хүргүүлсэн байх. Эрхзүйн актуудыг хуулийн хугацаанд хянуулж, өгөгдсөн зөвлөмжийн дагуу зөрчлийг арилгах. |
| 6 | Ирсэн, явуулсан бичгийн бүртгэл, СӨГ-ын бүртгэл зэргийг зааврын дагуу бүрэн бүрдэлтэй хөтөлж, мэдээ тайланд тоо баримтыг бодитой тусгах. Эрх зүйн актуудаа хуваарьт хугацаандаа бүрэн хянуулж, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах. |   |          |                                    |   |
| 7 | Байгууллагад хөтлөгдөх хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг 2019 оны байдлаар шинэчлэн гаргаж батлуулан жагсаалтын дагуу ажилтнуудаас баримтаа бүрэн бүрдэлтэй эмхлэн цэгцлүүлж, хүлээн авч хэвших.                               | 2019 оны ХХНЖ-ийг боловсруулан батлуулах  | 2-р сард | Баримт нягтлан комисс бичиг шалгах | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг дагуу баримтыг бүрэн бүрдэлтэй архивт хүлээн авсан байх  |

|    |   |  |          |                                    |   |
|----|---|--|----------|------------------------------------|---|
| 8  | Архивт хадгалагдаж байгаа баримтыг он цагийн хязгаараар эмхлэн цэгцэлж, байнга, түр, устгах хадгаламжийн нэгжийн бүртгэлийн зааврын дагуу гаргаж батлуулах.     | Байнга болон түр хадгалах баримт, устаг хэргийн жагсаалтыг гаргах  | 2-р сард | Баримт бичиг нягтлан шалгах комисс | ББНШАЗК-ын хуралдаанаар жагсаалт батлагдсан байх            |
| 9  | СӨГ-ын бүртгэлийг нэгдсэн байдлаар гаргах. Шийдвэрлэлтийн чанарт анхаарах.  | Иргэдээс төрийн байгууллагад ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийг бүртгэл хөтлөлтийг дэвтрээр хөтлөх, шийдвэрлэлтэд хяналт тавих | 2-р сард | М.Баярмаа                          | СӨГ-ийн тайланг хугацаанд нь бодитой гаргаж хүргүүлсэн байх |
| 10 | Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд ажлын гүйцэтгэлийг тайлагнах 89-ийн 5-р хавсралтын дагуу гаргаж тооцон, сайтад байршуулж, сурталчилах ажлыг хийх. | Төлөвлөгөөг цахим сайтанд байршуулсан байх.  | 2-р сард | Б.Амгаланжаргал                    | Мэдээллийн ид тод байдал хэрэгжинэ.                         |
| 11 | Хамаарал бүхий иргэдийн судалгааг гаргаж, мэдээллийн самбар болон сайтад байршуулж ажиллах.   | Цахим сайтанд байршуулсан байх. Хамаарал бүхий иргэдийн мэдэгдэл тайлбарыг цахимд тухай бүр оруулсан байх.                           | 2-р сард | Б.Амгаланжаргал                    | Мэдээллийн ид тод байдал хэрэгжинэ.                         |
| 12 | Хэрэгжилт тооцсон баримт бичигт тоо, хувийг баримттай тусгахаас гадна хэрэгжилтийг цэгцтэй, нэг загварт оруулж гаргаж хэвших.                                   | Тайлан мэдээг ЗГ-ын 89-р тогтоолын дагуу тайлагнах. Албан хэрэг стандартыг мөрдөж ажиллах.   | 2-р сард | М.Баярмаа                          | Тайлан мэдээ стандартын дагуу тайлагнагдана.                |

|    |   |   |               |                            |   |
|----|---|---|---------------|----------------------------|---|
| 13 | Хуулийн дагуу иргэнд газар өмчлүүлэх ажлыг эрчимтэй зохион байгуулах.   | 136 иргэнд газар өмчлүүлсэн байх.   | 1,2-р улиралд | Б.Нарандэлгэр              | Хуулийн дагуу иргэнд газар өмчлүүлсэн байна.  |
| 14 | 2019 оны Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол оруулж, судалгаа сайтай, бодитой төлөвлөх.   | Шинээр газар эзэмших иргэн ААН-н саналыг төлөвлөгөөнд оруулах.  | 1,2-р улиралд | Б.Нарандэлгэр              | Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийгдсэн байна.             |
| 15 | Сангийн хөрөнгөөр хийх 2019 оны ажлаа бодитой төлөвлөх, журам болон төлөвлөгөөний дагуу сангийн хөрөнгийг зарцуулж, үр дүнд хүрэх.                    | Төлөвлөгөө боловсруулсан байх.  | 1,2-р улиралд | У.Баянмөнх<br>Б.Сайхантуяа | Сангийн хөрөнгийг журмын дагуу зарцуулах.   |
| 16 | Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу ангийн орлогын 50 хувийг байгаль, ан амьтан хамгаалах үйл ажиллагаанд зарцуулах. | Ангийн орлогыг төлөвлөгөөний дагуу төвлөрүүлэх.   | 1,2-р улиралд | У.Баянмөнх<br>Б.Сайхантуяа | Ангийн орлогын 50 хувийг байгаль хамгаалах санд төвлөрүүлж, журмын дагуу зарцуулах. |
| 17 | Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1 дэх заалтын дагуу үйлдвэртэй /ингэний ферм/ болох асуудлыг шийдвэрлэх.           | Сум хөгжүүлэх сан болон бусад эх үүсвэрийн санхүүжилтээр сумандаа үйлдвэртэй болох анхан шатны эхлэл тавигдсан байх | 1,2-р улиралд | О.Цолмон                   | Орон нутгийн онцлогт тохирсон үйлдвэртэй болох                                      |
| 18 | Байгууллага бүр НБББББ-ийг боловсруулан даргын тушаалаар батлуулж, мөрдөж ажиллах.  | 2018 онд мөрдөж ажилласан НБББББ-нд шинээр гарсан ЗГ-ын тогтоол, журмыг тусгах.                                     | 2-р сард      | Байгууллагын дарга нар     | Санхүүгийн үйл ажиллагаанд НБББББ-аа мөрдөж ажилласан байна.                        |

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:.....Х.ХУНДМАА

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

2019-06-19

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа   | Хэрэгжилт   | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|-------------------|
| 1 | Байгууллагын ил тод байдлын үйл ажиллагааг жигдрүүлж, админ эрхээр хариуцах албан хаагчийг чадавхижуулах арга хэмжээ авч ажиллах. Аймгийн сайтын нүүр дээр онцлох мэдээллийг тухай бүр байршуулж байх.                        | Байгууллагын ил тод байдлыг хангаж, Дундговь сайтад админ эрхээр мэдээллийг байршуулан ажиллаж байна. Аймгийн сайтын нүүр дээр онцлох мэдээллийг байршуулан ажилласан. Одоогийн байдлаар сумын хэмжээнд төсвийн 6 байгууллагын 204 мэдээллийг оруулаад байна . Энэ өмнөх оноос ахисан үзүүлэлттэй байна.  | 90 хувь           |
| 2 | И-оффиссын програмын хандалтаа нэмэгдүүлэх.   | И-оффиссын програмд албан хаагчдаа тогтмол хамруулан ажиллаж байна.   | 70 хувь           |
| 3 | 2019 онд тухайн байгууллагад ашиглагддаг хэвлэмэл хуудасны нэр төрөл, индексийг тогтоож, батлан гаргаж мөрдөх.  | Сумын Засаг даргын 2019.01.02-ний өдрийн А/01 дүгээр захирамжаар ЗДТГ, төсөвт байгууллагуудын хэвлэмэл хуудсыг нэр төрлөөр нь индексжүүлэн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.  | 100 хувь          |
| 4 | СХЗҮТЗ-ийн 2011 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан баримт бичгийн стандартыг мөрдөж ажиллах.   | СХЗҮТЗ-ийн 2011 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан баримт бичгийн стандартыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.   | 70 хувь           |
| 5 | Хариутай бичигт бүртгэлийн зааврын дагуу бүрэн хөтөлж, мэдээ тайланд тоо баримтыг бодитой тусгах.   | 2019.06.10-ны байдлаар ЗДТГ-т 137 бичиг ирсэн бөгөөд үүнээс 68 хариутай бичиг, хугацаандаа шийдэвлэсэн 44, хугацаа хоцорсон 11, шийдвэрлэх хугацаа болоогүй 13 бичиг байна.   |                   |
| 6 | Ирсэн, явуулсан бичгийн бүртгэл, СӨГ-ын бүртгэл зэргийг зааврын дагуу бүрэн бүрдэлтэй хөтөлж, мэдээ тайланд тоо баримтыг бодитой тусгах. Эрх зүйн актуудаа хуваарьт хугацаандаа бүрэн хянуулж, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах. | Ирсэн, явсан бичиг болон өргөдөл гомдол санал хүсэлтийг бүртгэлийн дэвтрээр болон программаар давхар бүртгэж, хариутай мэдээ тайлангийн шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна. Мөн иргэдээс утсаар ирүүлсэн санал хүсэлтийг тусгай бүртгэлийн дэвтрээр хөтөлгөө хийж байна. 2019 онд 91 захирамж, 20 тушаалыг Хууль эрхзүйн хэлтэст хянуулж, | 100 хувь          |

|    |   |  |          |
|----|---|--|----------|
|    |   | өгөгдсөн зөвлөмжийн дагуу зөрчлийг арилгаж, хариуг хүргүүлсэн.   |          |
| 7  | Байгууллагад хөтлөгдөх хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг 2019 оны байдлаар шинэчлэн гаргаж батлуулан жагсаалтын дагуу ажилтнуудаас баримтаа бүрэн бүрдэлтэй эмхлэн цэгцлүүлж, хүлээн авч хэвших. | 2019 онд /ИТХ-д байнга хадгалах 12, түр хадгалах 12 баримт, ЗДТГ-т байнга хадгалах 39, түр хадгалах 57, 70 жил хадгалах 6 баримт/-ын хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтыг боловсруулан байгууллагын даргаар батлуулсан. 2018 оны байнга хадгалах 39, түр хадгалах 78, 70 жил хадгалах 6, нийт 123 баримтаар архивын нэгж үүсгэн хүлээн авсан. | 100 хувь |
| 8  | Архивт хадгалагдаж байгаа баримтыг он цагийн хязгаараар эмхлэн цэгцэлж, байнга, түр, устгах хадгаламжийн нэгжийн бүртгэлийн зааврын дагуу гаргаж батлуулах.                                     | 2010-2018 оны байнга хадгалах 356 хадгаламжийн нэгж, түр хадгалах 785, устгах 295 хэргийн бүртгэл, нийт 1436 баримтыг зааврын дагуу бүртгэл жагсаалтыг үйлдэн аймгийн БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн.   | 100 хувь |
| 9  | СӨГ-ын бүртгэлийг нэгдсэн байдлаар гаргах. Шийдвэрлэлтийн чанарт анхаарах.  | Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл гомдлыг бүртгэлийн дэвтрээр болон программаар бүртгэдэг. 1-р улирлын ӨГСХ-ийн тайланг хуулийн хугацаанд хүргүүлсэн бөгөөд 2-р улирлын тайлан хүргүүлэх хугацаа болоогүй байна.   | 100 хувь |
| 10 | Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд ажлын гүйцэтгэлийг тайлагнах 89-ийн 5-р хавсралтын дагуу гаргаж тооцон, сайтад байршуулж, сурталчилах ажлыг хийх.                                 | Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурдын тэргүүлэгчдийн 2019 оны 04 сарын 10 ны өдрийн 18 дугаар тогтоолоор 11 заалт бүхий төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэн ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 75 хувьтай байна.  | 70 хувь  |
| 11 | Хамаарал бүхий иргэдийн судалгааг гаргаж, мэдээллийн самбар болон сайтад байршуулж ажиллах.   | Сумын хэмжээнд төрийн байгууллаад ажиллаж буй хамаарал бүхий этгээдийн судалгааг гарган цахим сайтад байршуулсан.  | 100 хувь |
| 12 | Хэрэгжилт тооцсон баримт бичигт тоо, хувийг баримттай тусгахаас   | Албан тушаалтнуудаас гарч байгаа мэдээ тайлангийн албан бичгийн стандартыг хангуулах үүднээс 1 удаа албан хэрэг хөтлөлтийн сургалтыг зохион байгуулсан.  | 80 хувь  |

|    |   |   |          |
|----|---|---|----------|
|    | гадна хэрэгжилтийг цэгцтэй, нэг загварт оруулж гаргаж хэвших.   |   |          |
| 13 | Хуулийн дагуу иргэнд газар өмчлүүлэх ажлыг эрчимтэй зохион байгуулах.   | Энэ онд 133 иргэнд 11,8 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэхээр төлөвлөсөн. Хагас жилийн байдлаар газар өмчлөх 24 иргэний өргөдлийг хүлээн авч 2 га газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар шинээр олголоо. Мөн хамтран өмчилсэн газраа гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлэх-1, хаяг өөрчлөгдсөн-2 иргэний хүсэлтийг хүлээн авч хаягжуулалтын тухай хуулийн дагуу өөрчлөн өмчлүүлсэн.               | 40 хувь  |
| 14 | 2019 оны Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол оруулж, судалгаа сайтай, бодитой төлөвлөх.   | Сумын ИТХ-ын 2019 оны 04 сарын 19-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор 2019 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг тодотгон баталсан. Төлөвлөгөөнд үйлдвэр үйлчилгээний зориулалтаар 7 байршилд 8650м2 газрыг эзэмшүүлэхээр төлөвлөсөн. Газрын тухай хуулийн 33.1.2-т заасны дагуу 2 байршилд 1550м2 газрыг дуудлага худалдаа зохион байгуулж эзэмшүүлэхээр шийдвэрлэн дуудлага худалдааг mle.mn хуудсаар зарлаад байна. | 100 хувь |
| 15 | Сангийн хөрөнгөөр хийх 2019 оны ажлаа бодитой төлөвлөх, журам болон төлөвлөгөөний дагуу сангийн хөрөнгийг зарцуулж, үр дүнд хүрэх.                    | 2019 оны 04 сарын 19-ний өдрийн СИТХуралдаанаар Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хийгдэх хөтөлбөр төсөл, арга хэмжээг батлуулсан. Батлагдсан хөтөлбөр төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.   | 80 хувь  |
| 16 | Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу ангийн орлогын 50 хувийг байгаль, ан амьтан хамгаалах үйл ажиллагаанд зарцуулах. | 1 дүгээр багийн Их Баян уул, 2 дугаар багийн Тэвш нэртэй газар нутгуудад ан амьтны тандалт судалгаа хийгдэж, эргүүл хяналт шалгалтыг явуулсан.  | 40 хувь  |
| 17 | Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1 дэх заалтын дагуу үйлдвэртэй   | Шилийн хурд ХХК ингэний ферм байгуулахаар 100 сая төгрөгний төслийг ХХААХҮЯаманд хүргүүлсэн.  | 30 хувь  |

|                        |  |   |          |
|------------------------|--|---|----------|
|                        | /ингэний ферм/ болох асуудлыг шийдвэрлэх.  |   |          |
| 18                     | Байгууллага бүр НБББББ-ийг боловсруулан даргын тушаалаар батлуулж, мөрдөж ажиллах. | Төсвийн 6 байгууллага 2017 онд боловсруулан батлуулж, 2018-2019 онд мөрдөн ажиллаж байна. | 100 хувь |
| НИЙТ ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ |  |   | 82 хувь  |

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА:

Б.АМГАЛАНЖАРГАЛ

ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:

СА-НЫ ДАРГА:

Х.ХУНДМАА